



ЭДИЙН ЗАСАГ

- Төр эдийн засгийг ямар бодлогоор зохицуулдаг вэ?
- Төрийн мөнгө, зээлийн бодлогын зорилго юу вэ?
- Гадаад худалдаа, гадаад худалдааны бодлого
- Гадаадын хөрөнгө оруулалт
- Эдийн засгийн хөгжил



Хичээлийн зорилго



Эдийн засгийн хөгжил, өсөлт түүний шалтгаан, эдийн засгийн интеграцийн талаар ойлголттой болно.



Тооцоолол
хийх

Үр дүнг
тайлбарлах


Үзэл бодол,
байр суурь



ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Аливаа улс орны эдийн засгийн хөгжлийг ямар үзүүлэлтээр хэмжих вэ?

Эдийн засгийн өсөлт, хувиар



Бодит ДНБ өсөлт (ЭЗ
чадавхи)

Нэг хүнд ногдох ДНБ өсөлт
(иргэдийн амьжиргаа)



ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ



Эдийн засгийн өсөлтийн хурдыг хэрхэн тодорхойлох вэ?




$$\text{ЭЗӨ} = \frac{\text{ДНБ тайлан} - \text{ДНБ суурь}}{\text{ДНБ суурь}} \times 100\%$$

МУ-ын ДНБ (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 2007 онд 3324.6 тэрбум төгрөгт хүрч 2008 онд 3620.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2008 оны ЭЗӨ-ийг тооцоол.

$$\text{ЭЗӨ}_{2008 \text{ он}} = \frac{3620,5 \text{ тэрбум} - 3324,6 \text{ тэрбум}}{3324,6 \text{ тэрбум}} \times 100 = 8,9 \text{ хувь.}$$

Эдийн засгийн өсөлтийн хувь, 2016-2019

■ ДНБ, оны үнээр, их наяд төгрөг /зүүн гар/
■ Эдийн засгийн бодит өсөлт, хувь /баруун гар/





ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ



Ирээдүй хойч үеийнхний өөрсдийн хэрэгцээгээ хангахуйц чадварыг алдагдуулахгүйгээр өнөө үеийнхний шаардлагад нийцсэн хөгжлийг хэлнэ.
(НҮБ-ын тунхаглал)





ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ



Эдийн засгийн хөгжил эдийн засгийн өсөлт 2 юугаараа ялгаатай вэ?



Эдийн засгийн хөгжил нь эдийн засгийн өсөлтийг бодвол илүү өргөн хүрээтэй ойлголт.

- ✓ Амьжиргааны түвшин дээшилсэн
- ✓ Эдийн засаг өссөн
- ✓ Аж үйлдвэржилт болон бүтцийн өөрчлөлт бий болсон
- ✓ Эдийн засгийн бие даасан байдал нэмэгдсэн
- ✓ Ядуурлын түвшин буурсан
- ✓ Тогтвортой өсөлт бий болсон
- ✓ Хүний хөгжил сайжирсан

Хуучин цагт байгал нь өгөөжтэй улс орнууд хамгийн баян байлаа, өнөө үед хүн нь илүү бүтээлчулсорнууд хамгаас баян ажээ.

Хенри Бокл



Хүний хөгжлийн индекс

- I. Дундаж наслалт
- II. Боловсролын түвшин
- III. Амьжиргааны түвшин

Хүний хөгжлийн индекс гэдэг нь Хүний хөгжлийн түвшнээр нь улс орнуудыг дээд (Англи хэлээр very high), дээгүүр (high), дундаж (medium), доогуур (low) хэмээн зэрэглэхэд ашиглагддаг, холимог статистик хэмжигдэхүүн юм.

3

Үргэлжлэл

Монгол Улсын Хүний хөгжлийн индекс 2018



Empowered lives.
Resilient nations.

Хүний хөгжил гэдэг нь ХҮНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ АСУУДАЛ ЮМ. ҮҮНД ЭРҮҮЛ САРУУЛ АМЬДРАХ, СУУРЬ ХЭРЭГЛЭХ, ХАНГАГДАХ ЭРХ ХАМААРНА.



Монгол Улсын **68%** нь хотын иргэд



32% нь
хөдөө, орон
нутгийн иргэд.



Агаарын бохирдлоос шалтгаалсан **нас баралт** Монгол Улсад **100,000** хүн тутамд **155.9** байгаа нь дэлхийд маш өндөрт тооцогдох үзүүлэлт юм.

Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хий **7.1 ТОН** байгаа нь дэлхийд маш өндөрт тооцогдоно.

Монгол Улсын Засгийн газар эрүүл мэндийн салбарт төсвийн **3.9%**-ийг зарцуулж байгаа нь дэлхийн дунджаас **2.5 дахин бага** юм.

Монгол Улсын Засгийн газар боловсролын салбарт төсвийн **5.9%**-ийг зарцуулдаг.


Хүнс, тэжээлийн ДУТАГДАЛ:

Монгол хүн өдөрт **141 ккал**-ийн хэрэглээтэй байгаа нь дэлхийн дунджаас шим тэжээлийн дутагдал нь **2 ДАХИН ИХ** байна.




- ❑ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс жил бүр улс орнуудын хүний хөгжлийн индексийг шинэчлэн гаргадаг. Тус индексээр Монгол Улс энэ жил 92 дугаар байрт жагсаж, хүний хөгжлийн өндөр үзүүлэлттэй орнуудын тоонд багтжээ. Гэвч ижил бүлгийн орнуудаасаа гурав дахин бага орлоготой байна.
- ❑ Өөрөөр хэлбэл, Монгол Улсад орлогын тэгш бус байдал их гэсэн үг юм. Хамгийн их орлоготой 20% нь хамгийн бага орлоготой 20%-иасаа дунджаар 5 дахин их орлогын зөрүүтэй байдаг аж.
- ❑ Монголчуудын дундаж наслалт 69.5 бөгөөд энэ нь хүний хөгжлийн маш өндөр орны үзүүлэлттэй орнуудын дундажтай харьцуулахад даруй 10 жилээр дутуу юм.
- ❑ Бид дунджаар 15.5 жил суралцдаг бөгөөд энэ нь хүний хөгжлийн маш өндөр үзүүлэлттэй орнуудаас дөрвөн жилээр бага, дундаж үзүүлэлттэй орнуудтай харьцуулахад гурван жилээр илүү аж.

Figure 2.2: Ranking of Happiness 2015-2017 (Part 1)



НҮБ-ын Тогтвортой хөгжил Шийдлийн сүлжээ байгууллагаас жил бүр Дэлхийн аз жаргалын тайланг нийтлэн гаргадаг. “Аз жаргалын индекс”-ийг жил бүр 156 улсын иргэдээс санал асуулга авч, 0-10 хүртэлх оноогоор дүгнэн гаргадаг. Тэгвэл 2019 оны аз жаргалтай улсуудын жагсаалтыг дахин Финланд улс тэргүүллээ.



Source: TheGlobalEconomy.com, The World Happiness Report

Монгол улсын аз жаргалын индекс тогтмол өссөн үзүүлэлттэй байна. 2013 онд 4.83 байсан бол 2018 он гэхэд 5.13 болон нэмэгджээ. Монгол улсын хувьд 2018 онд дэлхийн 156 орноос аз жаргалын индексээрээ 94 дүгээр байранд жагсаж байсан бол 2019 онд 11 байраар ахиж, 83 дугаар байранд жагсав. Монгол Улсын хувьд “Аз жаргалын индекс” нь 5.285.

Дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч улс орнуудын иргэд тийм ч жаргалтай биш

Их Британи 15 дугаар, Герман 17 дугаар, Япон 58 дугаар, ОХУ 68 дугаар, БНХАУ 93 дугаар, АНУ 19 дүгээр байранд тус тус жагсчээ.

Харин хамгийн аз жаргалгүй улсаар буюу аз жаргалын индексээрээ 156 улсаас 156 дугаар байранд Өмнөд Судан жагсав.

ОУ-ын ЭЗ-ийн хамтын ажиллагаа, интеграци

“Интеграци” гэсэн үг нь integratio – нөхөх буюу integer- бүхэл бүтэн гэсэн утгатай латин үгнээс гаралтай.

- ❑ Интеграцчилал гэдэг нь – улс орнууд олон улсын хөдөлмөрийн хуваарьт нэгдэн орж өөрсдийн давуу талдаа түшиглэн харилцан нөхсөн хамтын ажиллагааны хэлбэрээр ажиллаж байгаа үйлдвэрлэлийн олон улсын хамтын ажиллагаа
- ❑ Олон улсын шинжтэй үйлдвэрлэлийн харилцаа



ОУ-ын ЭЗ-ийн хамтын ажиллагаа, интеграци



Улс орнуудын хоорондын интеграцийн эдийн засгийн утга санааг тухайн орны харьцангуй давуу талыг ашиглан бараа солилцох, зах зээлийг өргөтгөх, хамгийн ашигтай үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэлийн нөөцийг чөлөөтэй шилжүүлэх замаар тэдгээр улсуудын эдийн засгийн өсөлтийг дээшлүүлэхэд чиглэдэг гэж ойлгож болно.



Олон улсын эдийн засагт улс орнуудын эзлэх байр суурийг дараах шалгуураар тодорхойлж байна.

- I. Эдийн засгийн хөгжлийн түвшин
- II. Эдийн засгийн бүтэц
- III. Эдийн засгийн өсөлтийн төрөл
- IV. Гадаад эдийн засгийн хэлбэр




ОУ-ын ЭЗ-ийн хамтын ажиллагаа, интеграци



Европын Нэгдэл (ЕН) бол одоогоор Европ тивийн 28 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Урьд нь байсан Европын Нүүрс Гангийн Нийгэмлэг, болон Европын Эдийн Засгийн Нийгэмлэгийг 1958 онд нийлүүлж, 6 улсын гишүүнчлэлтэйгээр Европын Нийгэмлэгийг байгуулагджээ. Эхний хэдэн жилүүдээс гишүүд шинээр элссээр бүх талын үйл ажиллагаа нь өргөжсөөр 1993 оны Маастрихтын хэлэлцээрээр Европын Нэгдэл (ЕН) хэмээх одоогийн нэрээ авчээ.

Даяаршил улс орнуудын хөгжилд ямар дагавартай вэ?



Аль ч улсын хувьд гадаад ертөнцөөс хаалттай, тусгаарлагдмал байдлаар хөгжих бололцоогүй, хүссэн ч хүсээгүй ч олон улсын эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцох шаардлагатай болсон.



Даяаршил улс орнуудын хөгжилд ямар дагавартай вэ?



Даяаршил хүрээгээ тэлэхийн хэрээр түүнээс ихийг хүсэн хүлээж их зүйл хожих байх гэж найдаж байсан улс орнууд, ард түмний сэтгэл санаа тавгүйтэж эхлэв.



Эдийн засгийн зогсонги байдал, хүн амын хөгшрөлт, эрүүл мэндийн доройтол зэрэгт даяаршлыг буруутгах болжээ.



Даяаршил ажлын байрыг үгүй хийж, байгаль орчныг хордуулж, соёлын олон төрөл зүйлд заналхийлж байна.



АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА.